



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар E/06

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуульд хэсэгчлэн хориг тавих тухай

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдах хуулиудын хамт баталж, 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт ёсчлон ирүүлсэнтэй танилцлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг нийгмийн томоохон зөвшилцөл, ойлголцлын хүрээнд баталсан нь чухал алхам болсон боловч бодит үр дүн, улс орны хөгжил, ард иргэдийн амьдралд нийцэхүйц эргэлт, өөрчлөлтийг дагалдах хуулиудаар хийх нь нэн тодорхой юм.

Өнгөрсөн жилүүдэд бид Үндсэн хуулийнхаа үндэслэлийг элдвээр мушгин тайлбарлаж, үзэл санаа, зарчмыг нь салбар хуулиудаараа үгүйсгэн гажуудуулж ирсэн. Энэ бол давтаж боломгүй алдаа мөн бөгөөд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хуулийн шинэчлэл, өөрчлөлтийг хийхдээ анхаарвал зохих гол асуудал ч бас мөн болж байна.

Миний бие өнгөрсөн хугацаанд бий болсон нийгмийн гажуудлыг засах, хамтын зүтгэлээр хөгжин дэвжих боломжийг эрэлхийлэн олж, бүрдүүлэх нь төр, ард түмний үүрэг хэмээн үзэж, улс оронд үүсээд байгаа хүндрэл бэрхшээлүүдийг нэг мөр шийдвэрлэхийн тулд зайлшгүй авч үзэж сайжруулах шаардлагатай орхигдсон асуудлуудын хүрээнд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг санаачлан боловсруулж зохих журмын дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлсэн.

Миний өргөн мэдүүлсэн төслөөс дэмжигдэн батлагдсан нэг заалт нь Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт орсон “хууль санаачлах ...эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно” гэсэн энэхүү нэмэлт, өөрчлөлт юм. Үүнийг Үндсэн хуульд оруулах болсон гол үзэл баримтлал нь эрүүгийн болон иргэний хууль, төсөв, татварын хууль зэрэг мэргэжлийн яамны боловсруулбал зохих хууль, тогтоомжийг Улсын Их Хурлын гишүүн, мөн түүнчлэн Ерөнхийлөгч санаачилдаг байдлыг болиулах, Үндсэн хуулийн дараа эрэмбэлэгдэх ач холбогдол бүхий хуулиудыг мэргэжлийн өндөр түвшинд хийдэл, зөрчилгүйгээр боловсруулан баталж,

2020000046

сайжруулдаг байх, хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг дэлхийн улс орнуудын жишиг, өөрийн орны онцлог нөхцөлд нийцүүлэн хуулиар зөв тогтоох зэрэгт чиглэсэн болно.

Гэтэл Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа “Ерөнхийлөгч Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан үндсэн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачилна” хэмээсэн нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд огт нийцэхгүй, Ерөнхийлөгчийг сонгох зарчим, журмыг өөрчлөөгүй тохиолдолд хэрэгжих ямар ч бололцоогүй, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нийт ард түмнээс сонгогдсон, төрийн тэргүүн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэгчийн хувьд улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар хууль, тогтоомжийн төсөл санаачлахыг хязгаарласан, хэт субъектив санаа зорилго агуулсан зохицуулалт болжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан бөгөөд энэ зарчим хууль санаачлах эрхийн хүрээнд ч мөн адил үйлчлэх ёстой.

Өөрөөр хэлбэл хууль санаачлах эрхийн хүрээ хязгаарыг хуулиар тогтоохдоо тухайлсан байдлаар бус, тодруулбал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэгт заасан “Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Засгийн газар санаачилна” гэсэн зохицуулалтын хүрээнд нийтлэг байдлаар тогтоох нь зөв юм.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучингуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт хэсэгчлэн хориг тавьж байна.

Энэхүү хоригийг зохих хууль журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ үү.

Хавсралт ... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА